

# 2018 ЖИЛИЙН ТАЙЛАН

БидиСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИ











# АГУУЛГА

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ  
МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА

2018 ОНЫ ОНЦЛОХ  
ҮЙЛ ЯВДАЛ

НЭГДСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН



## ТУЗ-ЫН ДАРГА Б.ЛХАГВАДОРЖ ИЛГЭЭЛТ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, түнш байгууллагууд, хамтран ажиллагсад аа,

2018 он нь Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд өсөлтийн жил байсан бол “БидиСЕК ҮЦК”ХК-ийн хувьд ч амжилт бүтээлээр арвин жил байлаа.

Бид өнгөрсөн онд 57,430 харилцагчийн дансыг шинээр нээж харилцагчийн бааз сууриа 25%-аар нэмэгдүүлэн, Монгол Улсын анхны давхар бүртгэлтэй компани болох “Эрдэнэ ресорс девелопмент” компанийн IPO болон “Ард даатгал”ХК-ийн IPO, “Ачит зэс”ХХК-ийн хаалттай хүрээний давуу эрхийн хувьцааг зах зээлд амжилттай гаргалаа.

Компанийн орон нутаг дахь салбаруудын үйл ажиллагааг тогтмолжуулан, Улаанбаатар хот дахь төв байрны Үйлчилгээний танхимыг шинээр ашиглалтад оруулснаар үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн, харилцагчдын тав тухтай, хурдан шуурхай үйлчлүүлэх орчин, бололцоог бий болгоод байна.

Мөн online арилжааны систем болон харилцагчийн үйлчилгээний утсыг үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлснээр харилцагчдад өөрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран хүргэх бололцоотой боллоо.

Боловсон хүчний хувьд олон чадварлаг залуусыг хамт олны эгнээндээ нэгтгэж ажиллуулснаар нийт мэргэжилтний тоогоо өнгөрсөн оноос 30%-аар нэмэгдүүлж, үнэт цаасны компаниудаас хамгийн олон ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2018 оноос манай компани “shareholder activism” арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд өөрийн хөрөнгө оруулж, хувьцааг нь эзэмшдэг Хувьцаат компаниудтай илүү ойр хамтран ажилласны дотор салбартаа тэргүүлэгч, цаашид өсөлт хөгжил гаргах нөөц бололцоо бүхий 4 хувьцаат компани дээр тодорхой төслийг хэрэгжүүлэн, үйл ажиллагааг нь өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгохоор ажиллаж байна.

“БидиСЕК ҮЦК”ХК нь цаашид ч үйл ажиллагаандаа олон шинэлэг зүйлийг нэвтрүүлэн, хамтран ажиллагч байгууллагууд, харилцагчиддаа хамгийн шилдэг үйлчилгээг хүргэн, зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлэн ажиллахаа илэрхийлье.



# ТҮҮХЭН ЗАМНАЛ





## ЭРХЭМ ЗОРИЛГО


Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартад нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох

## ЗОРИЛТУУД

- Богино хугацаанд ● Гадаад Харилцааг Өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, ХОЗҮ-г өргөжүүлэх
- Дунд хугацаанд ● Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх.
- Урт хугацаанд ● Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох



# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ТУЗ-ЫН ДАРГА



**Б.ЛХАГВАДОРЖ**  
ТЭРГҮҮН ДЭД  
ЗАРИХАЛ

## ЕРДИЙН ГИШҮҮД



**Д.ДАЯНБИЛГҮҮН**  
ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

**Н.БАТГЭРЭЛ**  
ДЭД ЗАХИРАЛ,  
БИДИСЕК ҮЦК ХК

**ULUC BINGOL**  
ДЭД ЗАХИРАЛ,  
ИМПЕРА  
КАПИТАЛ

## ХАРААТ БУС ГИШҮҮД



**Д.АМГАЛАНБАЯР**  
ЗАХИРГААНЫ  
АЖИЛТАН,  
MSM LLC

**HITOSHI TANI**  
ЕРӨНХИЙЛӨГЧ,  
EXE GROUP

**Б.ЭНХБАЯР**  
ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ,  
EXE GROUP

**Б.АМАРСАНАА**  
ЗАХИРАЛ,  
ХЭРЭЭЖИ ХХК

**JAMES PASSIN**  
ПОРТФАЙЛ  
МЕНЕЖЕР

## ТУЗ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



**Б.ТЭМҮҮЛЭН**  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ИНСТИТУЦИОНАЛЬ ХАРИЛЦАГЧИЙН  
АЛБА, БИДИСЕК ҮЦК ХК

## ТУЗ-ЫН ДЭРГЭДЭХ ХОРООД

- Цалин Урамшууллын Хороо
- Аудитын Хороо
- Нэр Дэвшүүлэх Хороо



## БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Бид харилцагч, хөрөнгө оруулагч нартаа Монголын Хөрөнгийн Зах Зээл дээрээс хувьцаа, бонд худалдах, худалдан авах арилжаанд зуучлахаас гадна харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурласан мэдээ мэдээлэл зөвлөгөөг хүргэж ажилладаг.

### Харилцагчийн тоо

“БидиСЕК ҮЦК” ХК нь 2018 онд нийт 57,430 данс шинээр нээснээр нийт харилцагчдын тоо 250,000-д хүрсэн. Монгол улсын хөрөнгийн зах зээл дээрх нийт харилцагчдын 22% нь манай компаниар үйлчлүүлж байна.

#### Дотоод харилцагчид



#### Нийт харилцагчид



#### Гадаад харилцагчид



■ “БидиСЕК ҮЦК” ХК    ■ Бусад

### Нийт арилжаа

“БидиСЕК ҮЦК” ХК нь сүүлийн 9 жилийн байдлаар нийт зах зээл дээрх үнэт цаасны арилжааны 8-91%-ийг дангаар гүйцэтгэсэн.





## Салбарын үйл ажиллагаа

Засгийн газраас иргэдэд “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан иргэд үнэт цаасны дансаа нээлгэх үйл ажиллагаа эрс нэмэгдсэн. Компани нь үүнтэй холбогдуулан орон нутаг дахь салбаруудынхаа үйл ажиллагааг идэвхижүүлэн аймаг, сум орон нутгийн иргэдэд хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг хүргэж ажилласан.

Компанийн салбарын эрхтэй аймгууд:

- Дархан
- Эрдэнэт
- Төв
- Дорноговь
- Сэлэнгэ
- Булган

## Онлайн брокер


Харилцагчид вэб хөтчөөр гар утас, компьютер ашиглан **ХААНААС Ч, ХЭЗЭЭ Ч** Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох захиалгаа илгээх, дансны үлдэгдэл, гүйлгээ, мэдээллээ харах боломжтой “Онлайн брокер” үйлчилгээг нэвтрүүлсэн нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан, цаг хугацааг хэмнэсэн үйлчилгээ болсон.

## Арилжааны танхим

Хөрөнгө оруулагч, харилцагчиддаа арилжаанд шууд оролцох боломжийг бий болгосон, тав тухтай орчинг бүрдүүлсэн танхимыг бий болгон ажилладаг ба манай үнэт цаасны арилжаанд идэвхитэй оролцдог харилцагчид арилжааны танхимд ирж үйлчлүүлж байна.

## Мэдээлэл, судалгаа

Харилцагч нартаа өдөр тутмын арилжааны мэдээ, 7 хоногийн тойм, зах зээлийн мэдээ, мэдээллийг өөрийн вэб сайтаар дамжуулан цаг алдалгүй хүргэх зэрэг хөрөнгийн зах зээлийг сурталчлах, оролцогчдын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагааг байнга, идэвхитэй явуулж байна.





# ИНСТИТУЦИОНАЛЬ ХАРИЛЦАГЧИЙН АЛБА

2013 оны 04 сард байгуулагдсан Институциональ Харилцагчийн Алба нь томоохон байгууллагын болон гадаад харилцагчидтай харилцаж, захиалга авч, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, дотоодын харилцагчдад гадаадын зах зээлийн арилжааг /SAXO trading/ хариуцан ажилладаг мөн Хувьцаат Компани болон хөрөнгийн зах зээлтэй холбоотой томоохон судалгаа анализуудыг олон нийтэд хүргэдэг.

## Гадаад харилцагчид

### ХУВЬ ХҮН



### БАЙГУУЛЛАГА



Монголын Хөрөнгийн биржэд бүртгэлтэй нийт гадаадын хөрөнгө оруулагчдийн 50% гаруй нь манай компанийн харилцагч юм.

## Судалгаа, анализ

Бид гадаад болон дотоод хөрөнгө оруулагч, томоохон харилцагчиддаа зориулан Монголын эдийн засаг болон хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниудын талаарх мэдээлэл, тайлан, судалгааг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэж, харилцагчиддаа тогтмол хүргэн ажиллаж байна.

## Хөрөнгө оруулагчдын уулзалт

Бид өөрийн харилцагчид, Монголд хөрөнгө оруулалт хийхээр сонирхон судалж байгаа дотоод, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг хувьцаат компаниуд, төрийн байгууллага, Засгийн газрын нэгжүүдтэй хийх уулзалтыг тогтмол зохион байгуулдаг.



## ГАДААД АРИЛЖААНЫ ЗУУЧЛАЛ



Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2017 оны 05 сарын 11-ний өдөр “Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа”-ны зөвшөөрөл авснаар дотоодын харилцагчиддаа олон улсын зах зээл дэх үнэт цаасны арилжаанд оролцох бололцоог бүрдүүлээд байна. Компани нь тус үйлчилгээний хүрээнд олон улсын тэргүүлэгч онлайн брокер Саксо Групптэй хамтран ажиллаж байна. 2018 онд нийт 40,000 гаруй ам.долларын харилцагчийн захиалга биелсэн байна.

Saxo Bank нь 1992 онд байгуулагдаж, хамгийн анхны онлайн арилжааны платформ зохион бүтээж хувиараа хөрөнгө оруулагчдад мэргэжлийн хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын сангуудтай адилхан үйлчилгээг нэвтрүүлсэн.

### Давуу талууд

- Арилжааны платформыг өөрсдөө зохион бүтээсэн ба хамгийн цогц, ашиглахад хялбар, бүгдийг нэг дороос удирдаж болдог




- Дансаа цэнэглэх анхны хөрөнгө оруулалтын хэмжээ бага буюу 2,000 ам.доллар

- 28 хэлний сонголтоос өөрт хамгийн амар хэлээр платформоо удирдах боломжтой

- Иж бүрэн, чанарын өндөр түвшин бүхий судалгааг төлбөртэй болон төлбөргүй хэлбэрээр авч болно



## НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ




- "БидиСЕК ҮЦК" ХК
  - Бусад
- 2011 оноос хойш

## АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"БидиСЕК ҮЦК" ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэржилтэд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж, Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажиллаж байна.

Бид Монголын Хөрөнгийн Зах Зээлийн хамгийн том M&A хэлцэл (АПУ ХК, Эвэргрийн Инвестмент ХХК), анхны давхар бүртгэл (Эрдэнэ Ресурс Девелопмент компани) зэрэг анхны тодотголтой томоохон хэлцлүүдийг амжилттай гүйцэтгэж жил тутамд туршлагажсаар байна.





## ОНЦЛОХ ГҮЙЦЭТГЭЛ 2018 ОН

### АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ

“БидиСЕК ҮЦК” ХК нь 2018 оны 4 сард Монголын хөрөнгийн зах зээлийн анхны давхар бүртгэл болох “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн хувьцааг МХБ-д амжилттай бүртгүүлж, олон нийтээс 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт босгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийг дэлхий нийтийн жишиг хандлагын дагуу хөгжүүлэхэд чухал алхам болж чадсанаар онцлогтой байлаа.


### ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА

“Ачит Ихт” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол улсад анх удаа давуу эрхийн хувьцааг хаалттай хүрээнд буюу “Ачит Ихт” ХХК болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ажиллагсдад өөрийн 100 хувь охин компани болох “Ачит Зэс” ХК-иар дамжуулан санал болгон гаргасан.

“БидиСЕК ҮЦК” ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргах ажиллагааг зохион байгуулж ажилласан ба нийт 1.08 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж, “Эрдэнэт үйлдвэр” ба “Ачит Ихт” ХХК-ийн 300 гаруй ажилчид өндөр өгөөж бүхий давуу эрхийн хувьцааг эзэмшээд байна.

### ДААТГАЛЫН САЛБАРЫН АНХДАГЧ IPO

2018 оны 6 сард Монгол улсын даатгалын салбарын IPO-д анхдагчдын нэг болох Ард даатгал ХК-ийн IPO-д андеррайтераар ажиллаж, компанийн 7.5 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон нийт 5.25 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.





## SHAREHOLDER ACTIVISM

“БидиСЕК ҮЦК” ХК нь Shareholder activism хөдөлгөөнийг Монгол улсад анх удаа 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба нэг жилийн үр дүн гарахад ойртсон байна.

Бид Shareholder activism хөдөлгөөний хүрээнд өөрийн хөрөнгө оруулж, 8.6-33 хувийн хувьцааг нь эзэмшиж буй 4 компанийн орлого ашгийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг өсгөх зорилгоор шинэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгох талаар тус компаниудын ТУЗ-ийн үйл ажиллагааны хүрээнд бусад хувьцаа эзэмшигчид болон Гүйцэтгэх удирдлагын багтай нягт хамтран ажиллаж байна.

Дээрх компаниудын хувьд ашигтай ажиллах өндөр боломжтой хэдий ч сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллаж байгаа, менежмент, санхүүжилт болон маркетингийн тал дээр засаж сайжруулах шаардлагатай байгаа учраас бид “Shareholder Activism”-ийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж эхлэсэн.

- компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх;
- компанийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг бий болгох
- төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- шаардлагатай санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх;
- компанид хэрэгжүүлж болох хүний нөөц, маркетинг, IT-ын боломжуудыг харилцан нэвтрүүлэх;
- нэгж хувьцааны өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Одоогийн байдлаар 2 компанид гүйцэтгэх захирал шинээр томилогдож, ТУЗ-ийн бүтцэд өөрчлөлт оруулсан байна. Засаглалын бүтцэд үүсгэн байгуулагчид болон олонхоос гадна шинээр орсон төлөөллүүд идэвхтэй харилцан ТУЗ-ийн хурлын тоог тогтмолжуулах, олшруулах, компанид өрнөж буй асуудлуудад ТУЗ-ийн түвшинд хэрхэн дэмжлэг үзүүлэн ажиллах тал дээр хамтын ажиллагаа эхлүүлээ. Мөн компаниудад шинээр хэрэгжүүлж болох төслүүдийн санхүүжилтыг босгох тал дээр хамтран ажиллаж байна.



### 1. “Женко Тур Бюро” ХК

“БидиСЕК ҮЦК” ХК нь тус компанийн 33 хувийг эзэмшдэг ба ТУЗ-д 3 гишүүнийг компанийн зүгээс томилон ажиллуулж байна.

“Чингис хааны морьт хөшөө” цогцолбороор жил бүр зочилдог 150,000 зочин болон дайран өнгөрдөг 50,000-100,000 зорчигчдын урсгалд тулгуурлан Цогцолборын үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж, жуулчдад зориулсан иж бүрэн үндэсний хүрээлэн болгох төсөл. Үүнд:

- a. Food court
- b. Tourist Camp
- c. Хүүхдийн тоглоомын төв
- d. Худалдааны хэсэг /сувенир болон бусад/
- e. Бага театр /үндэсний үзүүлэн тоглолт/
- f. Музей
- g. Бусад





### 2. “Э-Транс ложистикс” ХК

“БидиСЕК ҮЦК” ХК нь тус компанийн 33 хувийг эзэмшдэг ба ТУЗ-д 3 гишүүнийг компанийн зүгээс томилон ажиллуулж байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох тээвэр ложистикийн үйл ажиллагааг өргөжүүлэхийн хамт,

компанийн байршлын давуу тал болон үйлчлүүлэгчдийн урсгалыг ашиглан Замын-Үүд дэх хамгийн том Худалдаа, үйлчилгээний төв байгуулах төсөл.

Компани нь МУ-БНХАУ-ын гол авто замын дагуу, улсын хилээс 500м-ийн зайд 5 га газар эзлэн оршдог. Замын-Үүдийн төв цэцэрлэг /Соёмботой хөшөө/ болон орон сууцны шинэ хорооллуудаас холгүй байршилтай, автомашин байрлуулах зам талбай сайтай.

МУ-БНХАУ-ын хооронд өдөр бүр 10,000-20,000 иргэн автомашинаар зорчдогоос гадна БНХАУ-ын талаас өдрийн жуулчлалаар тодорхой тооны иргэд тогтмол орж, МУ, ОХУ, БНСУ-ын тодорхой нэр төрлийн барааны худалдан авалтыг байнга хийдэг.



### 3. “МонИнжБар” ХК

“БидиСЕК ҮЦК” ХК нь тус компанийн 30 хувийг эзэмшдэг ба ТУЗ-д 2 гишүүнийг компанийн зүгээс томилон ажиллуулж байна.

Хот одоогийн дэд бүтцээ тэлж, шинэ суурьшлын бүс бий болгох, дагуул хотыг хөгжүүлэхэд дэд бүтцийг нарийн төлөвлөлттэйгээр, иж бүрнээр нь урьдчилан барьж байгуулах шаардлага тулгарч байгаа.

Дээрх асуудлыг улсын болон нийслэлийн төсвөөр байгуулах нь төсөвт ихээхэн ачаалал өгөхийн дээр маш их цаг хугацаа шаардсан ажил болохоор байгаа.

Иймд эдийн засгийн эргэлтэд хамгийн амархан орох бололцоотой үнэ цэнэ бүхий байршилд, дэд бүтцийн иж бүрэн бүтээн байгуулалтыг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулахаар төсөл боловсруулж байна.

Энэ төслийг амжилттай хэрэгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанаас гадна төсөлд хамрагдагсад буюу санхүүгийн байгууллага-төсөл хэрэгжүүлэгч /газрын эзэд болон барилгын компаниуд/-төслийн гүйцэтгэгч нарын хамтын ажил чухал үүрэгтэй юм.



### 4. “Шивээ-Овоо” ХК

“БидиСЕК ҮЦК” ХК нь тус компанийн 8.6 хувийг эзэмшдэг ба ТУЗ-д 1 гишүүнийг компанийн зүгээс томилон ажиллуулж байна.

Шивээ-Овоогийн бүс нутгийн нүүрсний орд нь нийт 29,500.0 га талбайг хамардаг бөгөөд нийт 2,708.7 сая тн нүүрсний нөөцтэй, 3 үндсэн хэсгээс бүрддэг томоохон нүүрсний орд юм.

Сүүлийн жилүүдэд уурхайн уулын ажлын/нүүрс олборлолт, борлуулалт, хөрс хуулалт/ хэмжээ тогтвортой нэмэгдэж нүүрсний дотоодын зах зээл дээр эзлэх байр суурь улам бүр бэхжиж байна.

“Шивээ-Овоо” ХК-ийн компанийн засаглалыг сайжруулах, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид та бүхэн бидний санаачлан эхлүүлсэн Shareholder activism хөдөлгөөнд нэгдэж, дээрх төслүүдийг хэрэгжүүлэхэд бидэнтэй хамтран ажиллах бүрэн боломжтой.



## ДОТООД АЛБА

“БидиСЕК ҮЦК” ХК-нау 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болох БиДиСиЭйПи ХХК нь оффисийн байрны түрээсийн орлого болон тогтмол зардал, ашиглалттай холбоотой засвар, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцдаг.

Компани нь өнгөрсөн онд 1 давхрын заалыг засан тохижуулж, харилцигчиддаа брокерын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх болсон.

Мөн компани үйлчилгээнийхээ чанар, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, хөрөнгийн биржийн өдөр тутмын арилжаа зэрэг цогц үйлчилгээг авч болох traderstation.mn-ийг нэвтрүүлэхээр бэлдээд байна. Түүнчлэн, “Алсаас арилжаанд” урианы дор онлайн захиалгын систем нэвтрүүлж одоогийн байлаар 200 гаруй харилцагчдад хүргээд байна.

Авто машинуудын найдвартай ажиллагаа болон засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийж, татвар, даатгалд, оношлогоонд хамруулж гарч болох эрсдэлээс сэргийлж ажилласан.

## ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ

Манай компани зөв, алсыг харсан, уян хатан, цогц хүний нөөцийн менежментийн стратегийг баримталдаг ба мэргэжилтнүүдээ сургах, хөгжүүлэх, цаашлаад оюунлаг, ёс суртахуунтай, эрүүл, өрсөлдөх чадвартай боловсон хүчнийг бий болгож төлөвшүүлэхийн төлөө хичээн ажилладаг.

Мөн компанийн мэргэжилтнүүдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол өсч одоогийн байдлаар 30 гаруй мэргэжилтнүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.


## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БидиСЕК ХК нь 2018 онд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Хөрөнгийн Зах зээлийн мэргэжлийн байгууллага, үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, ажиллагсдын дунд дулаан уур амьсгал, соёлч боловсон харилцааг бий болгоход ихээхэн анхаарч ажиллалаа.

Манай Компани жил болгон улсад төлдөг татварын хэмжээгээ үнэн зөв тодорхойлж, хуулийн хүрээнд найдвартай төлж ирсэн бөгөөд 2018 онд нийт .. Сая төгрөг татвар, Эрүүл Мэнд, Нийгмийн Даатгалын Шимтгэлд .. Сая төгрөг улсын төсөвт оруулжээ.

Мөн жил бүр уламжлан зохион байгуулдаг хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын дунд “BDSec CUP-2018”-ийг 13 дахь жилдээ, “Олон төрөлт тэмцээн”-ийг удирдан зохион байгуулсан.





603





# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн

Монголын хамгийн анхны давхар бүртгэлийг хийсэн



Erdene Resource Development



Орон нутгийн иргэдэд хаалттай хүрээнд, өндөр өгөөжтэй давуу эрхийн хувьцаа эзэмшүүлж

Монголын анхны нээлттэй даатгалын компанийн нэг болсон үүнд Андеррайтераар ажиллаж 5,25 босгосон






Онлайн брокерийн үйлчилгээ нэвтрүүлсэн

“GRAND BULL AWARDS 2018” ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд 2014-2018 оны ШИЛДЭГ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИ, ШИЛДЭГ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ гэсэн 2 нэр хүндтэй шагналын авсан





# НИЙТ ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ДҮН



Данс нээх


**+20%**

Онлайн брокер


**+224%**



## НИЙТ ХӨРӨНГӨ



## ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ






## ОРЛОГО



## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ







## ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, батлангажуулагч, хөрөнгийн болон  
бизнесийн үзлэгч, нөвлөх дүймчлэгч

Монгол Улс, Улаанбаатар хот-16066  
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5  
Утас: 70005401, 70005404, 70005405  
Факс: +976-70005403  
Э Шуудан: info@dalaivanaudit.mn  
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

##### Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БиДиСек ҮЦК” ХК болон түүний охин компани “БиДиСиЭйПи” ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол “БиДиСек ҮЦК” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

##### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Худалдааны болон бусад авлагын дүнд багтсан Дархан хөвөн ХК-аас авах 484,982.4 мянган төгрөгийн авлага сүүлийн 7 жилийн хугацаанд төлөгдөөгүй, хөдөлгөөнгүй ба эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй бөгөөд байгууллага тус авлагын эргэн төлөгдөх байдалд шинжилгээ хийж үнэ цэнийн бууралт орсон эсэхийг үнэлж тогтоогоогүй хэвээр байна. Аудиторууд аудитын нэмэлт горим гүйцэтгэж тус авлагуудын бодит үнэ цэнийг хэмжиж залруулга хийх боломжгүй байсан.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бүрэлдэхүүнд “БиДиСиЭйПи” ХХК-ийн эзэмшиж буй “БиДиСек ҮЦК” ХК-д оруулсан нийт 400,000.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгө оруулалт бүртгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ уг хөрөнгө оруулалтын хувьд нэгтгэлийн горимыг баримтлаагүйгээс нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн болон эздийн өмчийн үлдэгдэл тус дүнгээр илүү илэрхийлэгдэхэд нөлөөлсөн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын хязгаарлалттай дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.



### **Аудитын гол асуудлууд**

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### **Бусад мэдээлэл**

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

(үргэлжлэл)

- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлүүсээх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



2019 ОНЫ 02 ДУГААР  
САРЫН 19-НИЙ ӨДӨР



**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2018.12.31	2017.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5.1	63,771.2	2,015,230.3
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө	5.2	13,674,753.3	9,287,794.8
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө	5.6	506,732.9	778,166.2
Худалдааны ба бусад авлага	5.3	1,733,787.6	1,406,739.3
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>15,979,045.0</b>	<b>13,487,930.6</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	5.4	4,801,467.3	5,291,082.5
Биет бус хөрөнгө - цэвэр	5.5	18,106.9	17,825.8
Өмчөөр тайлагнагдах хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	5.8	1,000.0	1,000.0
Урт хугацаат авлага	5.7	53,284.0	98,259.7
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>4,873,858.2</b>	<b>5,408,168.0</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>20,852,903.2</b>	<b>18,896,098.6</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Худалдааны ба бусад өглөг	5.9	331,154.0	2,229,198.1
Банкны богино хугацаат зээл	5.10	861,312.8	668,308.1
Орлогын албан татварын өглөг	5.12	169,180.7	73,235.6
Бусад татвар, шимтгэлийн өглөг	5.12	83,553.6	74,371.9
Хүүний өглөг	5.11	17,485.0	6,417.2
Урьдчилж орсон орлого	5.13	242.2	160,000.0
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>1,462,928.3</b>	<b>3,211,530.9</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Банкны зээл урт хугацаат	5.10	2,197,824.6	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>2,197,824.6</b>	<b>-</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>3,660,752.9</b>	<b>3,211,530.9</b>
<b>ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	5.14	9,326,797.6	9,326,797.6
Дахин үнэлгээний нэмэгдэл	5.14	3,824,524.4	3,824,524.4
Хуримтлагдсан ашиг	5.14	4,040,828.3	2,533,245.7
<b>Нийт өмч</b>		<b>17,192,150.3</b>	<b>15,684,567.7</b>
<b>НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>20,852,903.2</b>	<b>18,896,098.6</b>



**НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	Тодруулга	/Мянган төгрөгөөр/	
		2018.12.31	2017.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	5.15	4,868,545.2	2,106,342.7
Бусад үйл ажиллагааны орлого	5.16	132,217.9	136,400.6
Үйл ажиллагааны зардал	5.17	(3,563,652.6)	(1,769,352.4)
<b>Үйл ажиллагааны ашиг/алдагдал</b>		<b>1,437,110.5</b>	<b>473,390.9</b>
Санхүүгийн орлого	5.18	481,058.9	758,591.5
Санхүүгийн зардал	5.18	(438,991.8)	(177,927.5)
Өмчөөр тайлагнагдах хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	5.19	116,445.9	141,898.8
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	5.20	95,944.1	(17,445.3)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)</b>		<b>1,691,567.6</b>	<b>1,178,508.4</b>
Орлогын татварын зардал	5.21	180,780.3	(80,154.8)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)</b>		<b>1,510,787.3</b>	<b>1,098,353.6</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс:</b>			
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилагдах зүйлс:</b>			
Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй олз/(гарз)		-	-
Хэрэгжээгүй олзод ногдох хойшлогдсон татвар		-	-
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		-	-
<b>Нийт дэлгэрэнгүй орлого/(зардал)</b>		<b>1,510,787.3</b>	<b>1,098,353.6</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)</b>			
Суурь (төгрөг)	5.22	110.3	80.2



## НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	Хувьцааг капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нооц	Үнэт цаасны БУЦ-ийн хэрэгжээгүй олз/(гарз)	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч	Мянган төгрөгөөр/
<b>2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,369,488.3</b>	<b>7,957,309.3</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>1,434,892.1</b>	<b>14,586,214.1</b>	
Гаргасан хувьцаа							
Халаасны хувьцаа							
Нэмж төлөгдсөн капитал							
Дахин үнэлгээний нэмэгдэл							
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз)							
Хуваарилсан ногдол ашиг							
Тайлант жилийн цэвэр ашиг							
Залруулга					1,098,353.6	1,098,353.6	
<b>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,369,488.3</b>	<b>7,957,309.3</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>2,533,245.7</b>	<b>15,684,567.7</b>	
Гаргасан хувьцаа							
Халаасны хувьцаа							
Нэмж төлөгдсөн капитал							
Дахин үнэлгээний нэмэгдэл							
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз)							
Хуваарилсан ногдол ашиг							
Тайлант жилийн цэвэр ашиг							
Залруулга					1,510,787.3 (3,204.7)	1,510,787.3 (3,204.7)	
<b>2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,369,488.3</b>	<b>7,957,309.3</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>4,040,828.3</b>	<b>17,192,150.3</b>	

WANGOMEAL



**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31

	/Мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2018.12.31	2017.12.31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<b>8,753,642.9</b>	<b>11,602,772.8</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,752,694.4	2,242,501.2
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		-
Бусад орлого	948.5	9,360,271.6
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<b>14,052,493.8</b>	<b>12,858,109.1</b>
Санхүүгийн хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө	9,549,946.4	4,268,853.5
Ажиллагсад төлсөн мөнгө	557,680.2	443,898.8
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	136,073.1	81,852.0
Түүхий эд, материал худалдан авахад төлсөн	61,088.2	29,550.1
Ашиглалтын зардалд төлсөн	25,573.2	48,196.7
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	21,131.1	38,664.9
Хүүний төлбөрт төлсөн	261,610.6	14,433.1
Татварын байгууллагад төлсөн	203,366.0	55,770.7
Шимтгэл хураамжид төлсөн	99,184.6	54,465.0
Даатгалын төлбөрт төлсөн	2,707.8	-
Бусад мөнгөн зарлага	3,134,132.6	7,822,424.3
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<b>(5,298,850.9)</b>	<b>(1,255,336.3)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<b>1,911,557.9</b>	<b>2,516,832.9</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	501,600.0	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хүүний орлогоос хүлээн авсан	271,203.0	
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		2,247,592.9
Бусад олгосон зээлийн эргэн төлөлт	1,138,754.9	269,240.0
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<b>1,221,507.2</b>	<b>17,525.3</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	24,336.2	17,525.3
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусад олгосон зээл	1,197,171.0	
<i>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<b>690,050.7</b>	<b>2,499,307.6</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<b>7,668,520.5</b>	<b>3,101,160.5</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,654,684.5	3,061,394.3
Бусад мөнгөн орлого	13,836.0	39,766.2
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<b>5,011,769.6</b>	<b>2,486,558.5</b>
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,011,769.6	2,486,558.5
Төлсөн ногдол ашиг		-
<i>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<b>2,656,750.9</b>	<b>614,602.0</b>
<i>Валютын ханшийн зөрүү</i>	<b>590.1</b>	<b>(9,655.3)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,951,459.1)</b>	<b>1,848,918.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,015,230.3	166,312.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,771.2	2,015,230.3



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө  
27/1, БиДиСЕК ҮЦК ХК

Утас: 7555 1919,  
И-мэйл: [info@bdsec.mn](mailto:info@bdsec.mn)

